

## МОНГОЛ УЛС, ОХУ-ЫН БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Э.Сувд<sup>1</sup>

*In this article, tried to put the education relationship between Mongolia and Russia after the collapse of the Soviet Union. Especially the governmental indenture between two of the countries and the agreement implementation in accordance with scholarship program.*

**Түлхүүр үгс:** *Монгол Улс, ОХУ, Засгийн газар, боловсрол, харилцаа, оюутан, тэтгэлэг.*

**Key words:** *Mongolia, Russian Federation, government, education, relation, student, scholarship.*

Хүмүүнлэгийн салбар дахь олон улсын хамтын ажиллагаа нь эрдэм шинжилгээний ажил, шинжлэх ухааны нээлтүүдийг хөхиүлэн дэмжих, соёл, боловсрол, эрүүл мэнд, спорт, аялал жуулчлалын харилцааг хөгжүүлэх, ард түмний уламжлалт соёлыг сурталчлан таниулах замаар тухайн үндэсний онцлогыг тодотгох, бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг өргөн хүрээг хамардаг төдийгүй улс хоорондын аюулгүй байдал болон тогтвортой хөгжлийг хангах, итгэлцлэлийн нийтлэг уур амьсгалыг бүрдүүлэх чухал хүчин зүйл болдог<sup>2</sup>.

ЗХУ-ын задарлаас хойш Монгол Улс нь нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого явуулж эхэлснээр улс төр, эдийн засаг, хүмүүнлэг, боловсрол, соёл зэрэг бүхий л салбарт гадаад харилцаагаа эрчимтэй хөгжүүлэх болсон.

1. Э.Сувд – ОХУ-ын Санкт-Петербургийн Их сургуулийн докторант

2. В.А.Родионов. Современные Российско-Монгольские отношения модели и сценарии. Улан-Удэ., 2013, 102 сс.

Монгол Улсын Засгийн газар нь 1990 оноос хойш Орос, Хятад, Япон, Солонгос, Казакстан, Турк, Франц зэрэг<sup>3</sup> нийт 17 орны Засгийн газартай гэрээ хэлэлцээр байгуулсаны үр дүнд монголын оюутан залууст эдгээр орнуудад тэтгэлэгт хөтөлбөрөөр суралцах боломж бүрдэж байна.

Монгол Улс, ОХУ-ын хооронд “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай” гэрээ 1993 оны 1 дүгээр сарын 20-ний өдөр байгуулагдсанаар хоёр орны харилцаа эрх зүйн шинэ шатанд шилжиж, соёл, боловсролын салбар дахь хамтын ажиллагаа Засгийн газар хоорондын гэрээний дагуу өргөжин хөгжих болов. Энэхүү гэрээний дагуу 1994 оноос эхлэн 25 оюутан, 5 аспирант ОХУ-ын Засгийн газрын тэтгэлэгээр сурах болсон байна. ОХУ-аас Монгол Улсад тэтгэлэгт хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх бодлого баримталж ирсэн бөгөөд 1996-1997 онд 60 оюутан, 30 аспирант, 1999-2000 онд 130 оюутан, 2000-2001 онд 150 оюутан, 2004-2005 онд 140 оюутан, 60 аспирант<sup>4</sup>, 2008-2009 онд 215 оюутан, 2011-2012 онд 300 оюутан, 2013-2014 онд 350 оюутан, 2014-2015 онд нийт 383 оюутанд тэтгэлэг олгосон бол 2015-2016 оны хичээлийн жилд 350<sup>5</sup> оюутан суралцах болсон байна. / Хүснэгт 1/



Засгийн газар хоорондын гэрээний дагуу 2013 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн тогтоолоор жил бүр ОХУ-ын их, дээд сургуулиудад 350 оюутан<sup>6</sup> (үүнд: Монгол Улсын иргэн, Монгол Улсад

3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам <http://www.meds.gov.mn>

4. А.Нямдолжин. Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбар дахь Монгол Улс, ОХУ-ын хамтын ажиллагаа, Олон улс судлал сэтгүүл. 2010 №1,2. 71-р тал.

5. 2015-2016 оны хичээлийн жилд ОХУ-ын их, дээд сургуулиудад суралцах элсэлтийн шалгалт авах журам <http://www.meds.gov.mn/data/1502/Russia2015.pdf>

6. 2015-2016 оны хичээлийн жилд ОХУ-ын их, дээд сургуулиудад суралцах элсэлтийн шалгалт авах журам <http://www.meds.gov.mn/data/1502/Russia2015.pdf>

суугаа харъяалалгүй иргэд болон Монгол Улсад байнга оршин суугаа оросын иргэд багтсан) тэтгэлэгээр суралцаж байна.

ОХУ-ын Ерөнхийлөгч Д.А.Медведев 2009 оны 8 дугаар сард Монгол Улсад айлчлах үеэр Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хооронд 2006 онд байгуулсан “Москвагийн тунхаглал”-ыг стратегийн түншлэлийн харилцаа болгон ахиулж “Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал”-д гарын үсэг зурснаар ОХУ-д цэрэг, техникийн чиглэлээр суралцах монгол оюутны тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарч үзэхээр болсон байна. Хоёр орны Засгийн газрууд нь хүмүүнлэгийн салбарт, түүний дотор багш, шинжлэх ухааны ажилтан, аспирант, дадлагажигчид солилцох, эрдэм шинжилгээний судалгаа хамтран хийх, хоёр орны их, дээд сургуулиудад суралцах тэтгэлэгийн тоог нэмэгдүүлэх тал дээр цаашид хамтран ажиллахаар тохиролцсон юм<sup>7</sup>. Москва хотноо 2013 оны 11 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд болсон Монгол, Оросын Засгийн газар хоорондын худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан, техник хамтын ажиллагааны комиссын 17 дугаар хуралдааны үеэр хоёр орны боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын Засгийн газрын тэтгэлэгээр суралцах монгол оюутны тоог цаашид нэмэгдүүлэх бодлого барьж байгаагаа оросын тал мэдэгдэн, ОХУ-ын Шинжлэх ухааны академийн дэргэдэх салбарын их сургуулиудад монгол залуу эрдэмтдийг мэргэжил дээшлүүлэх, сургахаар талууд тохиролцсон. Энэ бодлогын хүрээнд 2014 оны 09 сарын 03-нд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Монгол Улсад айлчлах үеэр Монгол Улсын Засгийн газраас ОХУ-д сургах оюутны тоог мянгад хүргэх санал тавьсан юм. Айлчлалын үеэр онцлох нэг гэрээ хийгдсэн нь ОХУ-ын “Роснефть” компани ОХУ-ын И.М.Губкины нэрэмжит Нефть, хийн их сургууль, М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн Улсын Их Сургууль, Москвагийн олон улсын харилцааны их сургуульд Монголоос 10 оюутан тэтгэлэгт хөтөлбөрт хамруулан суралцуулахаар болсон ба тус гэрээ нь Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, “Газрын тосны Роснефть” нийгэмлэг хоорондын хэлэлцээрийн<sup>8</sup> дагуу хийгдсэн юм. Гэрээнд тусгаснаар

7. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд Стратегийн түншлэлийг хөгжүүлэх тунхаглал <http://www.president.mn/content/163>

8. Монголия сегодня, 2014 №52 (653)

ОХУ-ын нэр хүнд бүхий сургуулиудын бакалаврын сургалтанд газрын тос, эрчим хүч, байгалийн шинжлэх ухааны чиглэл болон орос хэлний багшийн<sup>9</sup> мэргэжлээр сургах болсон ба бүх зардлыг оросын талаас даах, 100%-ийн тэтгэлэг олгохоор болов. Тус гэрээний дагуу 2015 оны хичээлийн жилээс эхлэн 10 оюутан тэтгэлэгт хамрагдан ОХУ-ын нэр хүнд бүхий их, дээд сургуулиудад суралцах болсон байна. Мөн “Эрдэнэт” үйлдвэр дээр тулгуурласан эрдэм шинжилгээний институт байгуулах талаарх саналын дагуу багш солилцооны ажлыг идэвхжүүлж, орос хэлний багш нарыг судалгааны лабораторид нь судалгааны ажил хийх боломжоор хангах талаар санал солилцсон зэрэг нь боловсролын салбарт хоёр орны харилцаа өргөжин тэлж байгааг харуулж байна. ОХУ-ын “Роснефть” компаниас монголд олгож буй 100 хувийн тэтгэлэг нь оросын зүгээс монголд оруулж буй бас нэг төрлийн бодлогын чанартай хөрөнгө оруулалт юм. Цаашид нефть, хий, газрын тос, байгалийн шинжлэх ухаан зэрэг монголд нэн хэрэгцээтэй салбаруудад чадварлаг мэргэжилтэн бэлтгэх нь хоёр орны цаашдын хамтын ажиллагаанд онцгой ашиг тустай байхаас гадна орос хэлтэй, оросын боловсролын системээр мэргэшсэн, чадварлаг боловсон хүчин бэлтгэгдэх чухал хүчин зүйлийн нэг болж байна.

Худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан, техник хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 18 дугаар хуралдааны үеэр хүмүүнлэг, боловсролын салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх талаар хэлэлцэж соёл, урлагийн чиглэлээр оюутны тоог нэмэгдүүлэхээр тохиролцсон. Энэхүү хэлэлцээрийн дагуу ОХУ-ын Соёлын Яам 2015-2016 оны хичээлийн жилд нийт 16 оюутанд тэтгэлэг олгосон байна. Энэ нь соёл, урлагийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх, соёлын ололтыг харилцан таниулж сурталчилах, боловсон хүчин бэлтгэх зэрэгт чухал ач холбогдолтой юм.

Сүүлийн жилүүдэд ОХУ нь боловсролынхоо салбарт хөрөнгө оруулж, гадаад улс оронд олгох тэтгэлэгт хөтөлбөрт төсвийн хэмжээг алдагдуулахгүй байх тал дээр анхаарч байна. ОХУ-ын төрийн дээд удирдлагууд боловсролын салбарт зарцуулах төсвөө жил бүр нэмж байгаа ба 2015 онд Ерөнхийлөгчийн нэрэмжит болон Засгийн газрын

9. ОХУ-ын Роснефть компанийн тэтгэлэгээр суралцуулна <http://www.meds.gov.mn/post150403>

тэтгэлэгт хөтөлбөрт 108 сая рублийг<sup>10</sup> төсөвлөсөн байна. Хэдийгээр энэ тоо тэтгэлэгт хамрагдаж буй оюутнуудад өртөг өндөртэй тус улсад амьдрахад тэр болгон хангалттай хүрэлцдэггүй ч төсөв, грантыг нэмэгдүүлэх тал дээр ОХУ-ын удирдлагууд цаашид тогтвортой бодлого баримталж байна.

2015 оны хоёрдугаар сард ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын дарга мөн “Оросын түүхийн нийгэмлэг” холбооны тэргүүний хувиар С.Е.Нарышкин, Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Ерөнхийлөгч Б.Энхтүвшин нар хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан<sup>11</sup>. Энэхүү санамж бичигт хоёр тал Монгол, Оросын ард түмний нийтлэг түүхэн уламжлалыг судлах, түүхийн шинжлэх ухааныг олон нийтэд түгээн дэлгэрүүлж сурталчилах зэрэг үндсэн дээр гэрээг зурсан ба “энэ нь өнгөрсөн үеийн сургамжийг харгалзан үзэж үндэсний болон дэлхийн хөгжлийн үндсийг тогтооход тус дэм болох юм” хэмээн үзжээ. Хамтын ажиллагааны хүрээнд хоёр тал түүхийн чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах, харилцан мэдлэг, мэдээлэл солилцох, хоёр орны харилцааны түүхэн дэхь онцлог үйл явдлууд, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан арга хэмжээнүүдийг бэлтгэх, зохион явуулах зэрэг чиглэлүүдээр цаашид хамтран ажиллахаар тохиролцсон байна<sup>12</sup>.

ОХУ-д 150 гаруй улсын 260 мянга<sup>13</sup> гаруй оюутан залуус 2015 онд суралцав. Үүний 2000<sup>14</sup> орчим монгол оюутан Засгийн газрын тэтгэлэгээр тус оронд сурч байна.

Сүүлийн жилүүдэд ОХУ нь орос хэлийг бусад улс орнуудад сурталчлах, орос хэлний багш нарыг бэлтгэх, онлайн сургалтыг хөгжүүлэх, орос орны хэл, соёл, уламжлалыг бусад улс оронд түгээн дэлгэрүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөрүүдийг эрчимтэй хэрэгжүүлж

10. Правительство выделил 23 миллиарда рублей на повышение зарплат бюджетникам. <http://www.kp.ru/daily/26319.4/3197796/>

11. С.Е.Нарышкин “Монгол-Оросын харилцааны түүх, уран зохиолын асуудал” сэдэвт дугуй ширээний уулзалтанд оролцов. <http://open.parliament.mn/content/5793.htm>

12. Монгол, ОХУ-ын түүхийн салбарын хамтын ажиллагаа үргэжилнэ. [http://www.mas.ac.mn/index.php?option=com\\_content&view=article&id=534:2015-02-16-10-%200523&catid=14&Itemid=122&lang=mn](http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&view=article&id=534:2015-02-16-10-%200523&catid=14&Itemid=122&lang=mn)

13. В вузах в России учатся студенты из 150 стран. <http://m.rg.ru/2015/05/26/diplomy-site.html>

14. С.А.Филин, Л.Дугаржав. Инновационное взаимодействие России и Монголии, УБ., 2014. 285 сс.

байгаа<sup>15</sup>. Энэ хөтөлбөрийн хүрээнд ОХУ нь Монгол Улсад орос хэл дээр үйл ажиллагаагаа явуулж буй боловсролын байгууллагуудын орос хэлний сургалтын чанарыг сайжруулах, ном, сурах бичиг, тоног төхөөрөмжөөр хангах зэрэгт дэмжлэг үзүүлэхэд анхаарч байна. Жишээлбэл 2015 онд “Орос хэлний зайн сургалт”<sup>16</sup> төслийн хүрээнд “Монгол Улсын мэдээлэл технологийн чадамжийг дээшлүүлэх үндэсний төв” төрийн бус байгууллага болон Оросын шинжлэх ухаан, соёлын төвийн хамтарсан сургалтын шинэ хөтөлбөр байгуулсан ба уг сургалтыг цаашид онлайн горимоор явуулна. Төслийн үндсэн зорилго нь хөдөө орон нутгийн орос хэлний багш нарын мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарч, оросын их, дээд сургуульд элсэн суралцах хүсэлтэй төгсөх ангийн сурагчдад орос хэл сурахад дэмжлэг үзүүлэхэд оршиж байна.

## ДҮГНЭЛТ

Монгол Улс нь 1990 оноос өмнөх 70 гаруй жилийн хугацаанд ЗХУ-ыг түшиглэн гадаад бодлогоо хэрэгжүүлж ирсэн ба хоёр орны уламжлалт соёл, боловсролын харилцаа нь Монголын боловсролын системд томоохон хувь нэмэр оруулсан. Өнөөдрийг хүртэл монголын ард иргэд оросын боловсролын систем, шинжлэх ухааны суурь судалгааг өндрөөр үнэлсэн хэвээр байна. Соёл, боловсролын салбар дахь хамтын ажиллагаа нь хоёр орны харилцааг улам хүмүүнлэг болгож, соёлын үнэт зүйлстэй танилцах, ард түмний уламжлалт харилцааг хөгжүүлэх зэрэг чухал ач холбогдолтой.

Хоёр орны Засгийн газарын хооронд боловсролын салбарт 90-ээд оны дунд үеэс хойш хийгдэж буй гэрээ хэлэлцээрийн дагуу ОХУ-ын зүгээс монгол оюутан залууст олгох тэтгэлэгийн тоог жилээс жилд нэмэгдүүлж ирсэн. Ялангуяа батлан хамгаалах, цэрэг, техникийн салбарт олгож буй тэтгэлэг нэмэгдэв. Монгол Улсад хамгийн сүүлд хэрэгжиж байгаа мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан “Орос хэлний алсын зайн сургалт” төсөл нь сургалтын хэлбэрийг

15. В мире насчитывается более миллиона иностранных выпускников российских вузов. <http://минобрнауки.рф/новости/5637>

16. ОШУСТ-д "Монгол улсад орос хэлний зайн сургалт" төслийн танилцуулга боллоо. <http://mn.russia.edu.ru/news/4528/>

хялбаршуулан, зардлыг хэмнэх боломжийг бүрдүүлсэнээрээ хоёр орны боловсролын салбар дахь хамтын ажиллагааг улам боловсронгуй болгож байна.

### **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

1. В.А.Родионов. Современные Российско - Монгольские отношения модели и сценарии. Улан-Удэ., 2013.
2. Монголия сегодня. №52(653), 2014.
3. Өдрийн сонин. №047(4999), 2015.
4. А.Нямдолжин. Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбар дахь Монгол Улс, ОХУ-ын хамтын ажиллагаа. Олон Улс Судлал сэтгүүл, 2010 №1,2
5. С.А.Филин, Л.Дугаржав. Инновационное взаимодействие России и Монголии. УБ., 2014.
6. <http://www.meds.gov.mn> / Боловсрол, шинжлэх ухааны яам/
7. <http://www.mongolia.mid.ru> /Посольство Российской Федерации в Монголии/
8. <http://www.kp.ru> /Комсомольская правда/
9. <http://минобрнауки.рф> /Министерство образования и науки Российской Федерации/
10. <http://m.rg.ru> /Российская газета/
11. <http://www.mas.ac.mn> /Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи/
12. <http://open.parliament.mn> /Нээлттэй парламент/
13. <http://mn.russia.edu.ru> /Оросын Холбооны Улсын Боловсрол, Шинжлэх ухааны яам/